



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/110

Бөхт


┌ Шууд гэрээ байгуулах эрх олгох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Босго үнэ тогтоох тухай” 124 дүгээр тогтоол, сумын Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар хийгдэх “Цог багийн Жаргалан энгийн уурхайн худаг засварын ажил”-ыг 1,500,000 (нэг сая таван зуун мянган) төгрөгөөр иргэн Б.Цогтсайхантай шууд гэрээ байгуулсугай.

2. Иргэн Б.Цогтсайхантай шууд гэрээ байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, ажлын уялдааг хангаж, гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга (Э.Сумъяа) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ